



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 442

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Соёлын сайдын (хуучнаар) багц) санхүүжүүлж бий болсон 7 нэрийн, нийт 5,462,628,839.00 (таван тэрбум дөрвөн зуун жаран хоёр сая зургаан зуун хорин найман мянга найман зуун гучин ес) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Билгээ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, хавсралтад заасан аймгийн орон нутгийн өмчит байгууллагад эзэмшүүлэх, бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
13602882
31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 16 дугаар сарын 16-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (СОЁЛЫН САЙДЫН (ХУУЧНААР) БАГЦЛААР
БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Бүртгэлд тусгах хөрөнгийн нэр, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Бүртгэх байгууллага
						Дугаар	Огноо	
Хэнтий аймгийн орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт								
1	Ханхэнтий чуулгын барилга (Хэнтий, Хэрлэн)	Барилга	м2	8021.8	4,907,627,488.00	ББКД-23- 19/2023	2023	Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар
2		Гадна дулааны шугам	м	86	27,899,713.00			
3		Цэвэр усны шугам	м	86	16,979,471.00			
4		Бохир усны шугам	м	132.2	31,021,165.00			
5		Гадна цахилгааны шугам	м	450	56,886,003.00			
6		Гадна тохижилт	м2	3035	105,851,553.00			
7		Зам талбай	м2	4350	316,363,446.00			
	НИЙТ ДҮН				5,462,628,839.00 (таван тэрбум дөрвөн зуун жаран хоёр сая зургаан зуун хорин найман мянга найман зуун гучин ес)			